



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

### Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн худалдан авах ажиллагааны газраас хариуцан зохион байгуулах “Ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.“Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-д заасан бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулж, бараа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, ерөнхий гэрээ байгуулан, цахим дэлгүүрт бүртгэхийг Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т даалгасугай.

3.Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

002211701

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 162 дугаар тогтоолын хавсралт

ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ АРГААР ХУДАЛДАН АВАХ  
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр	ХАА-д мөрдөх журам	Нийлүүлэгчийн тоо	Тендер шалгаруулалтын хэлбэр
1.	Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
2.	Чанар стандартын шаардлага хангасан дотоод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
3.	Чанар стандартын шаардлага хангасан импортын зарим хүнсний бүтээгдэхүүн	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
4.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
5.	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүн	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
6.	Боловсролын салбарын ширээ сандал, тавилга хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
7.	Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах тоног төхөөрөмж болон бусад цахим хэрэглэгдэхүүн	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
8.	Шинжлэх ухааны байгууллагын лабораторийн ширээ сандал, шүүгээ, багаж тоног төхөөрөмж	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
9.	Харааны бэрхшээлтэй хүүхэд дэмжих тоног төхөөрөмж	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
10.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
11.	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
12.	Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ

13.	Монгол гэр, гэрийн иж бүрдэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
14.	Нийтлэг хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, бараа материал, түүхий эд	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
15.	Төрийн захиргаа, нутгийн удирдлага, тусгай чиг үүргийн байгууллагууд болон уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашин	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
16.	Эрчим хүчний салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
17.	Уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
18.	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
19.	Төрийн байгууллагын нийтлэг хэрэгцээтэй программ хангамжийн үйлчилгээ	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
20.	Нүүрс тээврийн үйлчилгээ	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ
21.	Даатгалын үйлчилгээ	НТШ	Нэг буюу түүнээс дээш	Ерөнхий гэрээ